



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд боллоо.

Ёслолын ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Саран, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Алтансүх нар оролцлоо.



Төрийн захиргааны албан хаагчаар томилогдсон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа Нийслэлийн Мал эмнэлгийн Багануур дүүрэг дэх Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч Цэвээндоржийн Төмөрсүх, Нийслэлийн мал эмнэлгийн газрын Баганхангай дүүрэг дэх Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч Пүрэвдоржийн Цэрэнням нар **“Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ”** хэмээн Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөлөө.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ